

## БАТЛАН ХАМГААЛАХ САЛБАРТ 2019 ОНД ИРГЭДЭЭС ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫГ ШИЙДВЭРЛЭСЭН ТАЙЛАН

Монгол Улсын “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай” хууль, Засгийн газрын “Иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай” 2005 оны 67 дугаар тогтоол, Батлан хамгаалахын сайдын 2017 оны А/121 дугаар тушаалын хүрээнд Батлан хамгаалах яамны албан тушаалтанд иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэн иргэдэд хариуг өгч ажиллаа.

Нэг: Батлан хамгаалах салбарын хэмжээнд ирсэн өргөдөл гомдлыг шийдвэрлэсэн талаар;

2019 онд БХЯ болон харьяа байгууллага, албан тушаалтанд нийт 18796 иргэн хандаж санал, хүсэлт, гомдол ирүүлж 17768 өргөдлийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэж, 654 өргөдлийг холбогдох байгууллага, албан тушаалтанд шилжүүлэн шийдвэрлэж иргэнд хариу өгсөн нь 98 хувийн үзүүлэлттэй байна.

2019 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн байдлаар 61 өргөдлийн шийдвэрлэх хугацаа нь болоогүй шалган тодруулах ажиллагааг үргэлжлүүлэн явуулж байна.


Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийн:

- 14175 буюу 75.4 хувь нь бичгээр;
- 29 буюу 0,2 хувь нь цахимаар;
- 10 буюу 0,05 хувь нь утсаар;
- 4582 буюу 24.4 хувь нь биечлэн уулзаж өгсөн байна.

Хоёр: Батлан хамгаалах яаманд ирсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн талаар;

2019 онд БХЯ-нд албан тушаалтанд иргэдээс нийт 980 өргөдөл, гомдол ирүүлснээс 969 өргөдлийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэж, 10 өргөдлийг холбогдох байгууллага, албан тушаалтанд шилжүүлэн шийдвэрлэж иргэнд хариу өгсөн нь 98.8 хувийн үзүүлэлттэй байна. 2019 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн байдлаар 11 өргөдлийг шалган тодруулах ажиллагааг үргэлжлүүлэн явуулж байна.

2019 онд иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэсэн байдлыг 2018 оны мөн үеийнхтэй харьцуулбал:



2019 онд иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлыг ямар албан тушаалтанд хандаж гаргаснаар нь ангилж харуулбал:

– Батлан хамгаалахын сайдад	318 буюу 32.4 хувь
– Батлан хамгаалахын дэд сайдад	17 буюу 1.7 хувь
– Төрийн нарийн бичгийн даргад	175 буюу 17.9 хувь
– Төрийн захиргааны удирдлагын газарт	333 буюу 34.1 хувь
Бусад газар, хэлтсийн дарга нарт	22 буюу 2.2 хувь
– Орон сууцны комисст ирсэн байна.	115 буюу 11.7 хувь нь хаяглагдан

Гурав:Бусад байгууллагаас уламжлан ирсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн талаар;

2019 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Улсын Их Хурал, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Нутгийн болон захиргааны удирдлагын байгууллага, Батлан хамгаалах яамны харьяа байгууллагаас нийт 223 өргөдөл, гомдол шилжин ирснийг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохих шийдвэр гарган, хариу өгч ажиллалаа. Үүнд:

– Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газраас	19 буюу 8.5 хувь
– Монгол Улсын Их Хурлаас	31 буюу 14 хувь
– Төрийн захиргааны төв байгууллагаас хувь	59 буюу 26.5 хувь
– Нутгийн болон захиргааны удирдлагын байгууллагаас	11 буюу 4.9 хувь
– БХЯ-ны харьяа байгууллагаас хувь-ийг тус тус эзэлж байна.	103 буюу 46.1 хувь

Дөрөв: Өргөдлийг агуулгаар нь ангилбал;

Үүнд:

1. Орон сууц, гэр, хөнгөлөлт хүссэн	292 буюу 29.8 хувь
2. Ажлын байр хүссэн	152 буюу 15.5 хувь
3. Гадаад дотоодын сургууль, дамжаанд суралцах	145 буюу 14.8 хувь
4. Тэтгэвэр тэтгэмж,нөхөн олговор хүссэн	73 буюу 7.4 хувь
5. Ахмад дайчны үнэмлэх, тэтгэмж, орон сууц хүссэн	157 буюу 16 хувь
6. Хүүхдээ цэцэрлэгт элсүүлэх хүсэлт	79 буюу 8.1 хувь
7. Бусад эзэлж байна.	82 буюу 8.4 хувийг тус тус

Тав: Ил тод, нээлттэй байдлыг хангах чиглэлээр;


Яамны нээлттэй байдлыг хангах, иргэдэд санал хүсэлтээ чөлөөтэй илэрхийлэх бололцоог олгох зорилгоор нийт 6 сувгаар иргэдийн санал хүсэлтийг түргэн шуурхай хүлээн авч хуулийн хугацаанд нь шийдвэрлэж, иргэнд хариуг өгч ажиллаж байна. Үүнд:

- Биечлэн /Иргэд хүлээн авах байраар/
- Утсаар /458929 дугаарын утсанд/
- Засгийн газрын санал, хүсэлт хүлээн авах “11-11” төвөөс хуваарилагдаж ирсэн
- Шуудангаар /Цэргийн болон энгийн шуудан/
- Цахим хаягаар /tseren@mod.gov.mn/

Яамны вэб сайтаар / санал, хүсэлт хүлээн авах цонх/ тус тус хүлээн авч байна.

2019 онд иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын 905 буюу 92.3 хувь нь бичгээр, 29 буюу 3 хувь нь цахимаар, 46 буюу 4.7 хувь нь биечлэн уулзаж өгсөн байна.

2019 онд иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг 2018 оны мөн үеийнхтэй харьцуулбал:



Зургаа: Өргөдөл гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх хугацааг багасгах чиглэлээр;

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны хөтөлбөрийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан “Тогтвортой хариуцлагатай, эрх зүйт төрийг төлөвшүүлэх чиглэлээр төрийн захиргааны албан тушаалтан иргэдийн өргөдөл гомдлыг хүлээн авч шийдвэрлэх хугацааг хоёр дахин бууруулж, хөнгөн шуурхай болгоно” гэж заасны дагуу богино хугацаанд шийдэх боломжтой өргөдлийг хуулийн хугацааг хүлээхгүйгээр шийдвэрлэж хариуг өгч ажиллалаа.

Иргэдээс ирсэн өргөдлийг шийдсэн хугацаагаар харуулбал:

1-3 хоногт 150 буюу 15.3 хувь

4-7 хоногт 298 буюу 30.4 хувь

7-14 хоногт 173 буюу 17.7 хувь

14-30 хоногт 334 буюу 34.1 хувийг тус тус шийдэж хариуг өгсөн бөгөөд хуульд заасан хугацаа сунгаж шийдсэн 25 өргөдөл байгаа нь нийт өргөдлийн 2.5 хувийг эзэлж байна.

Шууд шийдвэрлэх боломжгүй, удаан хугацаанд шийдвэрлэгдэх асуудал /орон сууц, мөнгөн тусламж, сургалт гэх мэт/-аар гаргасан өргөдлийг тусгай бүртгэлд бүртгэн дараалалд оруулж, шийдвэрлэлтэд хяналт тавьж ажиллахын зэрэгцээ яамны эрхлэх асуудлын хүрээнд хамаарахгүй, албан ёсоор нийтэд зарласан асуудлаар гаргаагүй өргөдөл, гомдлыг харьяалах газарт нь 3 хоногийн дотор шилжүүлж энэ тухай иргэнд хариу мэдэгдэж ажиллалаа.


Иргэдэд өргөдлийн хариуг ихэвчлэн албан бичгээр өгдөг боловч зарим тохиолдолд биечлэн амаар буюу харилцах утсаар гэсэн аль болох түргэн шуурхай хүргэх тохиромжтой хэлбэрийг сонгон ажиллаж байна.

Долоо: Монгол Улсын Засгийн газрын 11-11 төвд ирсэн санал хүсэлтийг шийдвэрлэсэн талаар;


Засгийн газрын иргэдийн санал, хүсэлт хүлээн авах “11-11” төвд иргэдээс ирүүлсэн санал, гомдлыг цаг тухай бүрт нь хүлээн авч тодотгон, шаардагдах арга хэмжээ авч шийдвэрлэн, хариу илгээж ажиллалаа.

2019 онд 11-11 төвөөс 29 санал гомдол хуваарилагдаж ирсэн ба 13 нь гомдол, 16 нь санал хүсэлт байлаа.


## 1. Санал хүсэлтийг ангилж харуулбал:



## 2. Саналын төрлөөр харуулбал:



## 3. Шийдвэрлэлтийн төрлөөр харуулбал:



Найм: Байлдаанд оролцсон ахмад дайчид, түүний гэр бүлээс ирүүлсэн хүсэлтийг судалж, шийдвэр гаргах талаар:

Аймаг, Нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабуудтай хамтран байлдаанд оролцсон ахмад дайчдын судалгааг гаргаж нэгтгэн холбогдох албан тушаалтныг мэдээллээр хангаж ажиллалаа.

Байлдаанд оролцсон ахмад дайчинд тооцуулж, үнэмлэх олгох тухай хүсэлт гаргасан 21, байлдаанд оролцсон ахмад дайчдын ар гэр, үр хүүхдүүдээс орон сууцны дэмжлэг, мөнгөн тусламж хүсэж ирүүлсэн 157 өргөдөл, хүсэлтийг судлан үзэж холбогдох хууль, журмын дагуу шийдвэрлэн хариуг өгч ажиллалаа.

## ДҮГНЭЛТ:

2019 онд тавигдсан зорилго, зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаандаа иргэдээс ирүүлсэн ажил хэрэгч санал, хүсэлтийг судлан тусгах, Засгийн газраас иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг шуурхай, хүртээмжтэй байлгах зорилтыг хэрэгжүүлж, өргөдөл, гомдлыг хүлээн авах, зохих шийдвэр гаргаж хариу өгөх арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллалаа.

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗАР